

ШҮҮМЖ, НОМ ЗҮЙ

**«ТАЛ НУТАГ БА ХУВЬСГАЛ»
[Согэн то какумэй]**

Токио, 1971 он, 200 х.
«Сёбунся» хэвлэлийн
газар

Танака Кацухико

Японы монголч эрдэмтэн Танака Кацухико «Тал нутаг ба хувьсгал» гэдэг номоо монголын ардын хувьсгалын 50 жилийн ойд зориулан бичиж, 1971 онд нийтлүүлжээ. Тэрээр Токиогийн гадаад хэлний дээд сургуулийн монгол хэлний анги, Хитоцу-баси их сургуулийн аспирантурын нийгмийн ухааны факультет, мөн Бонны их сургуулийн философийн факультетын хэл шинжлэл, угсаатны зүй, түүх зүйн ангийг тус тус суралцан төгсч, монголын түүхийн холбогдол бүхий хэд хэдэн өгүүлэл, зохиол бичсэнээс гадна, Х. Чойбалсангийн «Монголын хувьсгалын товч түүх»; Баруун Германы монголч эрдэмтэн Хайссигийн «Монголын түүх, соёл» зэрэг зохиолыг монгол, герман хэлнээс орчуулжээ.

Зохиогч хоёр бүлэгтэй уг зохиолынхоо эхний бүлгийн 14 зүйл тус бүрийг 1969 онд «Асахи», «Нихондокусё» зэрэг японы төвийн сонин, хэвлэл, мөн 10 гаруй судалгаа-сурталчилгааны сэтгүүлд нийтлүүлж байжээ.

Японы түүхчид Монголын нэн шинэ үеийн түүх болон 1921 оны ардын хувьсгалын үйл явц, хувьсгалаас хойших Монгол орны хөгжил, байдлыг манай орны түүхэн баримт бичиг, зохиол, намын их хурлуудын материалд тулгуурлан бодитойгоор бичиж эхлэж байгаа явдал нь япон дахь монголын түүх судлалын нэг амжилт юм.

Зохиогч К. Танака уг зохиолдоо монголын ардын хувьсгалын өрнөлтийг нэлээд иш үндэстэй тайлбарлахдаа «1921 оны 7-р сард Сүхбаатар, Чойбалсан зэрэг залуу хувьсгалчдын уриалгаар малчин ардыг гол хүчин болгон бүрэлдэн тогтсон ардын арми нь Зөвлөлт оросын Улаан Армитай хамтран Нийслэл хүрээ, өөрийн ард түмнийг олон жилийн харийн дайсны дарлалаас чөлөөлж, хятадын болон цагаантны цэргийг шахан зайлуулав» (х. 73) гээд энэхүү хувьсгалын ач холбогдлыг зөвхөн монголын ард түмний хувьд төдийгүй, олон улсын хэмжээн дэх үйл явдал гэж дүгнэжээ.

Зохиогч хувьсгалт хөдөлгөөн өрнөх үеийн чухал чухал үйл явцыг юуны өмнө, Амарсанаа, Чингүнжав нарын удирдсан хятад-манжийн эсрэг бослогын үргэлжлэл нь Аюуш, Тогтох нарын ядуу малчин ардын тэмцэл гэж үзээд монголын үндэсний тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөнийг Алс Дорнодын Коминтерны газар болон Алс Дорнодын БНУ-ын хувьсгалт зүтгэлтнүүд идэвхтэй дэмжиж байсан ба Сүхбаатар, Чойбалсан нар Эрхүү хотноо хувьсгалын тактик, стратегийн сургуулийг заалгаж, Гембаржевский, Черненко зэрэг оросын хувьсгалчидтай ойртон нөхөрлөж, Зөвлөлт Орос улстай ажил хэргийн холбоо тогтоох

арга замыг ойлгон авч, өөрийн орныг социализмын замаар хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа өрнүүлсэн тухай дэлгэрэнгүй бичсэн байна. «Монголын ард түмэн XX зуунд аж төрөн амьдарч дэвшин цэцэглэж байгаа бодит туршлага, зовлон бэрхшээлийн урт удаан замыг даван туулж БНМАУ-ыг байгуулсан түүхэн замнал» (х.6)-ыг зохиогч ардын хувьсгалын үр нөлөөтэй холбож үзжээ.

Ардын хувьсгалыг бэлтгэн явуулах үе, түүний ялалтын дараа үед шийдвэртэй үүрэг гүйцэтгэж ирсэн Сүхбаатар тэргүүтэй тууштай тэмцэгч нарын олон талт хувьсгалт үйл ажиллагааны талаар зохиогч монгол, орос хэл дээрх дурдатгал, намтар, баримт бичиг болон түүхэн өгүүлэл, зохиолыг иш хэрэглэгдэхүүн болгон ашигласан байна. Тухайлбал, ардын журамт цэргийн татлага явуулж байсан Сүхбаатар, Чойбалсан нар, Эрхүү дахь Коминтерны төлөөлөгч, хувьсгалт байгууллагын анхны сонин «Монголын үнэн»-г гардан хэвлэж байсан яруу найрагч, зохиолч Буяннэмэх, монголын баруун хязгаарт өрнөсөн цагаантны эсрэг тулалдаанд шийдвэрлэх ялалт байгуулсан Хатанбаатар Магсаржав, тэмцэгч Хасбаатар, монголын ард түмний тусгаар тогтнолын төлөө амь биеэ хайрлахгүй тэмцсэн партизан Авирмэд, Дандар баатар зэрэг хувь хүний гавьяа, үйл ажиллагааг тодорхой өгүүлэн бичжээ. Дээрх түүхэн материалаас зохиогчийн анхаарал татсан зүйлийн нэг бол «1921 оны монголын малчин ардын хувьсгал нь жинхэнэ ёсоор янз бүрийн чиг хандлагыг хамаарч тусгаар тогтнолын төлөө, хятадын эсрэг нэгдсэн фронт болон өрнөсөн явдал юм». (х. 125)

Ийнхүү «малчин ардын зэвсэгт тэмцлийг» зохион байгуулахад шийдвэрлэх роль гүйцэтгэсэн Сүхбаатар болон түүний хувьсгалт дайчин нөхдийн нэрийг Японд мэдэх болсон явдал нь харьцангуй шинэ зүйл юм.

Монголын ардын хувьсгал нь олон арван сэхээтэн хүмүүсийн оролцлогтой өрнөснийг зохиогч мөн онцлон тэмдэглэсэн байна. Тусгаар тогтнолын төлөө тэмцлийн шинж чанарыг харуулахдаа, Сүхбаатарт бичиг үсэг зааж өгч, түүнтэй ажил төрлийн тогтмол холбоотой байсан Жамъян-гүн, Гэгээрлийн яамны дэргэд байгуулагдсан «Судар бичгийн хүрээлэнгийн» үйл ажиллагаа, буриад Жамцараногийн эрдэм шинжилгээний салбарт ном зүй судлалаар хийсэн ажлыг жишээ болгон дурджээ. Монголын ардын намын III их хурлын түүхэн ач холбогдол бол «ардын нам нь ардын хувьсгалт нам гэж нэрлэгдэх болж, их хурлаас Монгол орныг социализмын замаар хөгжүүлэх шийдвэр гаргаж, ерөнхий боловсролын асуудлыг хурцаар дэвшүүлэн тавьсан явдал» юм гэж бичсэн байна.

Зохиогч энд хувьсгалын эхний жилүүдээс монголын соёл, утга зохиолын салбарт явуулж ирсэн арга хэмжээ, зорилт, түүний хөгжлийн тухай тодорхой өгүүлээд, «Нууц товчоо», «Өнчин цагаан ботгоны тухай» үлгэрийн хэсгээс тайлбарлан орчуулж, монголын ардын аман зохиол, тэдгээрийн цуглуулга нь өнөө үе маш үнэт зүйл болоод байгааг тэмдэглэсэн байна, (х. 58) Орчин үеийн монголын утга зохиолыг үндэслэгч Д. Нацагдоржийн «Цагаан сар ба хар нулимс» гэдэг зохиолыг монголын эрт эдүүгээн амьдралын өөрчлөлтийг сайтар тусгаж чадсан зохиол гэж үнэлжээ.

Зохиогч энэхүү номдоо япон-монголын харилцаанд холбогдох хэд хэдэн баримт үйл явдлыг дурдан бичсэн нь анхаарал татах зүйлийн нэг юм.

Хувьсгалаас өмнө японы империалистууд Хойт хятад ба Монгол аймгийг хуваарилан нөлөөлж байх талаар Хаант орос улстай зохицож харилцан үүрэг авч байсан учир Ар Монголыг эзлэхийг эртнээс ихээ-

хэн эрмэлзэж байв. 30-аад оноос японы төрийн зүтгэлтнүүд БНМАУ-ыг эрхшээл нөлөөндөө оруулж авах зорилгоор түрэмгий үйл ажиллагаагаа идэвхжүүлж Халх-голын дайныг дэгдээхэд хүрсэн юм. Ийнхүү ХХ зууны эхний хагаст японоос монголын талаар явуулж ирсэн бодлогод «зэвсэгт хүчинг ашиглах тал давамгайлж, японы монгол судлал» ч судалгааны ажилдаа «цэргийн хүчнийг ашиглаж байсныг» зохиогч үнэн зөв тэмдэглэсэн байна. (х. 6) Халх-голын дайныг «зөвхөн жижиг овоо, газрын төлөө зөрөлдөөн биш, харин Дорнодахин болон Азийг эзлэж авах эрмэлзэлтэй байсан японы армийн Халх голын орчим үйлдсэн томоохон өдөөн хатгалга» (х. 114) гэж тайлбарласан нь Халх-голын дайны мөн чанарыг сүрхий бүрхэгдүүлдэг Японы бусад түүхчдийн бүтээлтэй харьцуулахад зарчмын ялгаатай байна. Зохиогч дайнаас хойших Монгол орны байдлыг тодорхойлохдоо, «БНМАУ нь НҮБ-ын гишүүнээр элсч, түүний нэр олон улсын тавцан дээр гарч ирснээс хойш дэлхийн олон арван орон Монгол улсыг хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоох болсон» гээд харин «монголын асуудал нь японы засгийн газрын бодлого америкаас нөлөөлж байсныг толь шиг тусгаж, тэдний чин сэтгэлийн үүднээс биш, харин хөрөнгө капиталын сонирхолд хөтлөгдөн бодлогоо явуулдгийг харуулж чадав» гэж зохиогч тэр үед монголын талаар баримталж байсан японы засгийн газрын гадаад бодлогыг оновчтой дүгнэж хэлсэн байна. (х. 7)

Октябрийн хувьсгалын дараа хөрөнгөтөн орнууд капитализмын ерөнхий хямрал, зөрчилд автагдан орж, 1930, 1940-өөд оны үед японы империалистууд түрэмгий бодлогоо үйлдэж байсан үед японы ард түмэн, түүний ажилчин анги олон улсын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд нэгдэн орж тэмцэж байв. МАН-ын III их хурлын илтгэлд Катогийн засгийн газрын харгис бодлогын эсрэг явуулж буй японы ажилчин ангийн тэмцлийг өндөр үнэлжээ. Зохиогч үүнтэй холбогдуулан манай «Утга зохиол» сонины 1969 оны 7-р сарын 11-ний дугаарт 1922 онд Москвад болсон Алс Дорнодын хөдөлмөрчдийн их хуралд оролцсон япон, монгол зэрэг Азийн орны төлөөлөгчид Ленинтэй уулзсан тухай өгүүлэл нийтлэгдснийг дурдсан байна. Түүнээс үзэхэд Японы төлөөлөгч Ёсида дээрх уулзалтын талаар дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөж, үүнийгээ тэр жилийн (1922 онд) «Кайзо» сэтгүүлийн № 12 нийтлүүлсэн байна. (х. 83) Түүнчлэн төлөөлөгчдийн гишүүн монголын зохиолч С. Буяннэмэх японы төлөөлөгчдийн Ленинтэй уулзсан тухай 2 тэмдэглэл бичиж, нэгийг нь «Үнэн» сонины 1930 оны 1-р сарын 22-ны дугаарт, хоёрдохийг нь «Хувьсгалт залуучуудын эвлэл» сэтгүүлийн 1935 оны №1-т тус тус нийтлүүлжээ. (х. 83) Ийнхүү хувьсгалын жилүүдэд монгол, японы дэвшилт хэсгийн төлөөлөгчид нэгэн үзэл санааны дор тэмцэж бие биеэ танин мэдэж байсан явдал зохиогчийн анхаарлыг зүй ёсоор татжээ. Ийм ч учраас «Алс Дорнодын хөдөлмөрчдийн их хурал нь Азийн хоёр орон Япон, Монголыг харилцан ойртуулах цэг болж, япон-монголын ард түмний хооронд тогтсон урьдны баримтлал нь шинэ утга чанарын харилцаатайгаар үүсэн хөгжих болов» (х. 96) гэж зохиогч тэмдэглэжээ.

БНМАУ-ын түүх судлал, түүхэн материалын ач холбогдлын талаар зохиогчийн хийсэн ерөнхий дүн шинжилгээ номын сүүлийн бүлэгт тусгагджээ. Сүүлийн үед БНМАУ-д явуулж буй монголын нэн шинэ үеийн түүх судлал, түүхийн материалын нийтлэлд 1921 оны монголын тусгаар тогтнолын үеийг шинэ талаас тусган гаргаж, ардын армийн тэмцлийг тодорхой бичих болсныг зохиогч онцлон тэмдэглэсэн байна. (х. 122—123) Нөгөө талаар Япон дахь монголын түүх судлалын байдал, түүний дутагдалтай сул талыг анхаарч «50-аад оны дундаас БНМАУ-д

түүх судлалын салбарт хийгдсэн судалгааны ажил дэлхийд өндөр үнэлэгдэж, монголын судлал нь одоо монголчуудын мэдэлд очоод байгаа» (х. 40) учир «бидний хувьд орчин үеийн Монгол орныг танин мэдэхэд түүхийн материалыг үл харгалзах явдал аюултай» (х. 182) гэж цохон тэмдэглэжээ.

Түүх судлалд үнэт тус нэмэр болох зүйл бол үнэн бодитойгоор бичсэн дурдатгал, дурсамжууд юм. Хувьсгалын үеийн түүхэнд холбогдолтой түүний дотор ардын хувьсгалын ялалттай холбогдсон дурдатгал, дурсамжууд нэлээд нийтлэгджээ.

«Тал нутаг ба хувьсгал» гэдэг номыг бичихдээ, зохиогч «хувьсгалыг олон талаас нь гүнзгий ойлгоход тус дөхөм үзүүлэх, үйл явдлыг хэсэгчилэн тусгасан, чухал үнэ цэнэтэй зүйлийг агуулсан» түүхэн баримт бичиг, дурдатгал, тэмдэглэлүүдийг тухайн бүрд нь дурдаж тэдгээрийн ач холбогдлыг ихэд үнэлсэн байна. Үнэхээр ч хувьсгалын түүхэнд холбогдох түүхийн материал нь ардын хувьсгал бол жинхэнэ нийт ард түмний хувьсгал байсныг гүнзгийрүүлэн судлахад ихээхэн дөхөмтэй баримт бичиг болох юм.

К. Танака нь энэхүү судалгааны зохиолдоо хэдийгээр хувьсгалын үеийн, хувьсгалаас хойш Монгол орны дотор явагдсан ардчилсан өөрчлөлт, хөгжлийг бүрэн тусгаж чадаагүй боловч, 1921 оны монголын хувьсгалын түүхэн ач холбогдлыг тодорхойлж, хувьсгалын үеийн гол гол үйл явдал, хувь хүмүүсийн роль тэмцлийг манай орны баримт сэлтэд тулгуурлан бодитойгоор бичих гэж оролдсон нь тэмдэглүүштэй зүйл бөгөөд япон дахь орчин үеийн монголын түүх судлалд шинэ хандлага оруулж байгаагийн нэг гэрч юм.

О. Оюунгэрэл